



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Баянхонгор аймгийн Нэгдсэн эмнэлгийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: БНА-2020/171/СТА-ТШЗ

Баянхонгор 2020 он	Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат Утас: 99007576 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn Аудитын менежер: А.Цээням Утас: 88089024 Цахим хаяг: tseenyama@audit.gov.mn Аудитор: П.Амаржаргал Утас: 99890393 Цахим хаяг: amaraa_802002@yahoo.com Цахим хуудас: www.audit.mn
-----------------------	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

Агуулга

Аудитын гэрчилгээ	3
Аудитын тайлан.....	5
2.1. Оршил	5
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	5
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	5
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	6
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	6
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал.....	7
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	7
2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	8
2.11. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	9
2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	12
2.13. Шилэн дансны мэдээлэл	12
2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт	12
2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	12
Аудит хийгдсэн санхүүгийн тайлан.....	13
1.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан	13
4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	14
4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан	15
4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	17
4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	18
4.6 Аудит хийгдсэн нэмэлт санхүүжилтийн тайлан.....	20



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

64101 Баянхонгор аймаг,
Баянхонгор сум, Номгон баг
Утас, факс 7044 2584
E-mail: bayankhongor@audit.gov.mn

Г БАЯНХОНГОР АЙМГИЙН НЭГДСЭН
ЭМНЭЛГИЙН ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Ч.ЖАВЗАН
ТАНАА

᠒᠐᠒᠐.᠐᠘.᠒7 № 248
танай _____ -ны № _____ -т
Г _____ Г
Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-т заасны дагуу Баянхонгор аймгийн Нэгдсэн эмнэлгийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Баянхонгор аймгийн Нэгдсэн эмнэлгийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Баянхонгор аймгийн Нэгдсэн эмнэлгийн 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийн хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон

D:\бичиг хэрэг 2020-Албан тоот А4\ * 005020205

удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-т заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудитын хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ



Б.МӨНХБАТ

D:\бичиг хэрэг 2020-Албан тоот А4\

2.1. Оршил

Баянхонгор аймгийн Нэгдсэн эмнэлгийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Ч.Жавзан танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянхонгор аймгийн Нэгдсэн эмнэлгийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баянхонгор аймгийн Нэгдсэн эмнэлгийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 01 дүгээр сарын 17-ноос 2020 оны 01 дүгээр сарын 22-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 02 дугаар сарын 27-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор П.Амаржаргал хариуцаж хэрэгжүүлэв.

Баянхонгор аймгийн Нэгдсэн эмнэлгийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2020 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн 32 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Баянхонгор аймгийн Нэгдсэн эмнэлгийн үйл ажиллагааны эрхэм зорилго нь “Эрүүл мэндийн анхан шатны болон эмнэлгийн тусламж үйлчилгээг чанартай, шуурхай хүргэж үйлчлүүлэгчдэд ээлтэй орчин бүрдүүлэн, хувь хүн хамт олны идэвхтэй оролцоонд тулгуурлан эрсдэлтэй зан үйлийг өөрчлөх, эрүүл аж төрөх ёсыг хэвшүүлэх замаар хүн амын эрүүл мэндийг сайжруулахад” оршино.

Баянхонгор аймгийн Нэгдсэн эмнэлгийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Нийгэм эрүүл мэндийн тусламж үйлчилгээ
- Эх барих эмэгтэйчүүдийн тусламж үйлчилгээ
- Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих гэрийн сувилахуй, сэргээн засах, өдрийн эмчилгээ, оншилогоо эмчилгээ

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт гараагүй байна. Дараах хууль тогтоомжийг мөрдөж байна.

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2019 оны Төсвийн тухай хууль
- Эрүүл мэндийн тухай хууль

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус Баянхонгор аймгийн Нэгдсэн эмнэлгийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Баянхонгор аймгийн нэгдсэн эмнэлэг нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд “Санхүүгийн тооцоолох групп” ХХК-ийн “Acolous” программ хангамж ашигладаг байна.

Баянхонгор аймгийн Нэгдсэн эмнэлгийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Баянхонгор аймгийн Нэгдсэн эмнэлгийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 35 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж, гүйцэтгэж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг дунд гэж үнэлэн, материаллаг байдлын хувь хэмжээг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүнг 2019 оны 3 дугаар улирлын санхүүгийн үр дүнгийн тайлангийн 8731196,8 мянган төгрөгөөс тооцон 87311,9 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2019 оны жилийн эцсийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 8867271,1 мянган төгрөгөөр тооцон 88672,7 мянган төгрөгөөр тооцож үзсэнтэй холбоотой юм.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Баянхонгор аймгийн Нэгдсэн эмнэлгийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 3054452,25 мянган төгрөгөөр буюу 1,9 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	583,885.74	601,623.69	17,737.96
33	АВЛАГА	5,283.80	5,283.80	0.00
35	БАРАА МАТЕРИАЛ	578,601.94	596,339.90	17,737.96
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	8,771,751.13	11,808,465.42	3,036,714.29
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	13,309,326.30	16,252,270.50	2,942,944.20
	Хуримтлагдсан элэгдэл	-4,537,575.20	-4,443,805.10	-93,770.10
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	9,355,636.87	12,410,089.12	3,054,452.25
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	9,355,636.87	12,410,089.12	3,054,452.25
51	Засгийн газрын хувь оролцоо	9,355,636.87	12,410,089.12	3,054,452.25
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	9,355,636.87	12,410,089.12	3,054,452.25

Бараа материалын дансны үлдэгдэл өмнөх оноос 17737,96 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь "Глобал" сангаас 13856,4 мянган төгрөг, ХӨСҮТ-ээс 12019,0 мянган төгрөг, ЭМЯ-наас 3723,0 мянган төгрөгийн эм бэлдмэл, НИК ХХК-аас шатахууны

урамшуулал 1691,0 мянган төгрөгийн шатахуун нийт 31289,4 мянган төгрөгийн үнэ төлбөргүй бараа материал орлого авсантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл өмнөх оноос 2942944,2 мянган төгрөгөөр нэмэгдсэн ба энэ нь ЭМЯ-ний хөрөнгө оруулалтаар 3316000,0 мянган төгрөгийн 50 ортой хүүхдийн эмнэлгийн барилга орлого авсан, 6000,0 мянган төгрөгийн аппарат, 7000,0 мянган төгрөгийн Нярайн дулаацуулах ширээ, 206027,8 мянган төгрөгийн Суурин ЭХО аппарат, 31500,0 мянган төгрөгийн Фургон авто машин, Өвөр монголын эмч нар 4500,0 мянган төгрөгийн зүрхний бичлэгийн аппарат, Баянхонгор хөгжлийн төлөө сангаас 15500,0 мянган төгрөгийн Мэс заслын хагалгааны ор, ЭХО аппарат, Баянхонгор сумын ЗДТГ-аас 14665,0 мянган төгрөгийн Шүдний кресло ком, Их мөнх наран ХХК-аас 2600,0 мянган төгрөгийн нярайн шарлагын аппарат, НҮБ-ын сангаас 39659,0 мянган төгрөгийн Төрөх эмэгтэйчүүд сургалтын хэрэглэгдэхүүн, Ринчинбол сангаас 16950,0 мянган төгрөгийн тоног төхөөрөмжүүд, Далай ээж ХХК-аас 300,0 мянган төгрөгийн гал тогооны шүүгээ, иргэн н.Батгэрэлээс 5340,0 мянган төгрөгийн Монитор Цахилгаан насос, Д.Ганхүлэгээс 3500,0 мянган төгрөгийн Нярайн фото аппарат, яаралтай тэргэнцэр, н.Мянгандаваагаас 4605,0 мянган төгрөгийн тоног төхөөрөмжийг тусламж хандиваар хүлээн авч орлогоор бүртгэн авсан харин 814040,7 мянган төгрөгийн балансын үнэтэй үндсэн хөрөнгийг аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн 2019 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 130 дугаар тогтоолыг үндэслэн актлан данс бүртгэлээс хассан байна.

Тайлант онд 714663,8 мянган төгрөгийн элэгдлийн зардал тооцсон ба хуримтлагдсан элэгдлийн дүн 4443805,1 мянган төгрөг байна.

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 12410089,1 мянган төгрөг болж 3054452,2 мянган төгрөгөөр өссөн байна.

2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Баянхонгор аймгийн Нэгдсэн эмнэлэг нь тайлант онд үндсэн үйл ажиллагааны орлогын төлөвлөгөө 154871,0 мянган төгрөг батлагдаж 172367,6 мянган төгрөгөөр орлогын төлөвлөгөөг биелүүлж 17496,7 мянган төгрөгийн давсан орлогыг Монгол улсын сангийн яамны Төрийн сангийн газрын даргын 2019.12.25-ны 12-1/8507 тоот албан бичиг, аймгийн Засаг даргын 2019.12.16-ны А/652 тоот захирамжаар нэмэлт санхүүжилтийн орлого зарцуулах зөвшөөрөл авсан дагуу зарцуулсан байна.

Тайлант онд төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 71602 хөтөлбөрт зориулан 80101 /үндсэн үйл ажиллагаа/, 80219 /харуул хамгаалалтын зардал/, 80802 /ажил олгогчоос олгох тэтгэмж/, 81611 /Төр хариуцах эмнэлгийн тусламж/-д зориулалттай 8047112,1 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас урсгал зардалд зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлыг 3941128,6 мянган төгрөгийг улсын төсвөөс, 3950956,1 мянган төгрөгийг Эрүүл мэндийн даатгалын сангаас, 154870,9 мянган төгрөгийг өөрийн үйл ажиллагааны орлогоос нийт 8047112,1 мянган төгрөгийг санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

152681,7 мянган төгрөгийг үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон орлогоос

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Зардлыг санхүүжүүлсэн орлогын гүйцэтгэлийг төлөвлөлттэй уялдуулан шалгахад:

Тайлант онд улсын төсвөөс авах 3941128,6 мянга, ЭМДС-гаас 3950956,1 мянган төгрөг, өөрийн үйл ажиллагааны орлогоос 154870,9 мянган төгрөгийг оруулж, 8046628,8 мянган төгрөгийг гүйцэтгэлээр нь санхүүжүүлж 483,2 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 8046628,8 мянган төгрөг буюу 100 хувьтай байгаа нь улсын төсвөөс 8047112,1 мянган төгрөгийн санхүүжилт авч урсгал үйл ажиллагаанд зарцуулж 483,2 мянган төгрөг хэмнэгдэн төвлөрүүлсэнтэй холбоотой байна.

Нэмэлт төсөв: Урьдчилсан сэргийлэх үзлэгийн санхүүжилт 101760,5 мянган төгрөг, аймгийн ЗДТГ-аас 2800,0 мянган төгрөг, ЭМЯ-наас өсвөр үе залуучуудыг тогтворжуулах зардалд 8000,0 мянган төгрөг, төслийн санхүүжилт Эрдэнэмонгол ХХК-аас 17700,0 мянган төгрөг, Гэмтэл согог судлалын үндэсний төвөөс 2480,0 мянган төгрөг, АйВиКо интранешил ХХК-аас 500,0 мянган төгрөгийн хандив, актын төлбөр 1944,0 мянган төгрөг, үндсэн данснаас үйл ажиллагааны давсан орлого 17496,7 мянга, нийт 152681,7 мянган төгрөгийн нэмэлт санхүүжилтийн дансанд орж ирснийг зарцуулсан байна.

2.11. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 35 эрсдэлийг үнэлж гүйцэтгэх үе шатанд 25 эрсдэл тодорхойлж нийт 25 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 6995,2 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрч 1891,1 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 306,9 мянган төгрөгийн албан шаардлага, 4869,3 мянган төгрөгийн 2 заалт бүхий зөвлөмж өгөв.

1. Худалдан авах тендерийн гэрээ болон техникийн тодорхойлолтод цэвэрлэгээ, ахуйн хэрэглээний материал худалдан авахаар заасан байхад хог хаягдал зайлуулах хортон мэрэгчдийг устгал ариутгалын зардлаас Шижир титэм ХХК-д 769.5 мянган төгрөгийг шилжүүлж нэг бүр нь 9500 мянган төгрөгийн үнэтэй 81 ширхэг бичгийн цаас худалдан авсан байна. Мөн МТД ХХК-тай 2019.01.09-ны өдрийн №04 тоот гэрээний дагуу мэдээ мэдээлэл, шууд нэвтрүүлэг бэлтгэн зар сурталчилгаа хийх зардлыг санхүүжүүлэхдээ урсгал засварын зардлаас шилжүүлсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, 16.5.2. “Батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих”, 41 дүгээр зүйлийн 41.2.2- д “Батлагдсан төсвийн хүрээнд зардал гаргах”, Сангийн сайдын 2014 оны 55 дугаар “Эдийн засгийн ангилал батлах тухай” тушаалын 6 дугаар хавсралтаар батлагдсан “Хог хаягдал зайлуулах хортон мэрэгчдийг устгал ариутгалын зардал, урсгал

засварын зардал” гэсэн төсвийн зарлагын ангиллаас тус тус гаргасан, “Үнэн зөв байдал” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоох

2. Нийгмийн даатгалын хэлтэст 2019 оны сард 12-р сард Н.Пүрэвсүрэнгийн цалинг 400.0 мянга, Л.Батгэрэлийн цалинг 480,3 мянга, нийт 880.0 мянган төгрөгийн цалин илүү мэдээлж шимтгэлийг төсвөөс төлсөн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2.” Батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих” Нийгмийн даатгалын тухай хуулийн 17 дугаар зүйлийн: 1.Ажил олгогч болон энэ хуулийн 4 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан даатгуулагч нь шимтгэл төлөх талаар дор дурдсан үүрэг хүлээнэ:

1/хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлого болон түүнд оногдох шимтгэлийг үнэн зөв тодорхойлж, тогтоосон хугацаанд төлөх; гэсэн заалт “Үнэн зөв байдал” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоох

3. Нэгдсэн эмнэлгийн даргын үүргийг тор орлон гүйцэтгэгч Ч.Жавзанд холбогдох эрх бүхий байгууллагын тушаал шийдвэргүйгээр ажил хавсарсны нэмэгдэл 2019 оны 12-р сард 360.4 мянган төгрөгийн цалинг олгосон байна.

Энэ нь ажил хавсарсны нэмэгдлийг холбогдох дээд байгууллагын тушаал шийдвэргүйгээр төсвийн хөрөнгийг зарцуулсан байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоох

4. Б.Санчир нэхэмжлэгчтэй Баянхонгор аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүхчийн 2018 оны 12 дугаар сарын 11-ны өдрийн Дугаар 131/ШШ2018/00982 тоот захирамжийн дагуу ажилгүй байсан хугацааны цалингийн НДШ, ЭМД шимтгэлийг нөхөн төлсөн байна.

Энэ Төрийн албаны тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.1.”Төрийн жинхэнэ албан хаагчийг хууль бусаар төрийн албанаас чөлөөлсөн, түр чөлөөлсөн, халсныг төрийн албаны төв байгууллага, эсхүл шүүх тогтоосон бол төрд учруулсан хохирлыг уг шийдвэрийг гаргасан буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлнэ”, Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлийн 103.1-т "Иргэн, хуулийн этгээдийн хохирлыг барагдуулсны улмаас өөрт учирсан хохирлыг захиргааны байгууллага Иргэний хуулийн 498.5-д заасны дагуу гэм буруутай албан тушаалтнаар буцааж төлүүлнэ гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөх

5. Эмнэлэгт хэвтэн эмчлүүлэгчийн хоолны зардлаас 2019.06.14-нд "Хөдөлмөрийн чадвар алдалтыг тогтоох төрийн бодлого зохицуулалт үр дүн" сэдэвт баруун бүсийн зөвлөгөөний хоолны зардлын үнэнд 3600.0 мянга, 2019.05.15-нд эмч

нарын хоолны үнэнд 390.0 мянган төгрөгийг тус тус Гал хонгор ХХК, мөн Өлзийт палас ХХК- д 322.5 мянган төгрөгийг тус тус шилжүүлж төсвийг зориулалт бусаар зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5.2.батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих” 16.5.5-т “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, 41 дүгээр зүйлийн 41.2.2- д “Батлагдсан төсвийн хүрээнд зардал гаргах” Сангийн сайдын 2014 оны 55 дугаар “Эдийн засгийн ангилал батлах тухай” тушаалын 6 дугаар хавсралтаар батлагдсан “Хоол хүнс /Эмнэлэгт хэвтэн эмчлүүлэгчийн хоолны зардал” гэсэн төсвийн зарлагын ангиллаас гаргасан, “Үнэн зөв байдал” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөвлөмж өгөв

6. Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйл худалдан авах тендерийг сонгон шалгаруулахдаа техникийн тодорхойлолтод хөрөнгийн шинжтэй зардлыг тусгаж батлагдсан зардлыг зориулалт бусаар зарцуулж байна.

Энэ Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5.2.батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих” 16.5.5-т “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, ТБОНӨХБАУХАТ хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.2-т “Үндэсний стандарт, техникийн шаардлага, норм, норматив, дүрэм, зааварт үндэслэх, үндэсний стандарт, техникийн норм байхгүй тохиолдолд Монгол Улсын хүлээн зөвшөөрсөн олон улсын стандартад үндэслэх” гэсэн заалтыг зөрчсөн.

Шийдвэрлэсэн нь: Зөвлөмж өгөх

7. Нэмэлт дансны давсан орлого 17.4 мянган төгрөг, урьдчилсан сэргийлэх үзлэгийн 97,3 сая төгрөгийг зарцуулахдаа Монгол улсын сангийн яамны Төрийн сангийн газрын даргын 2019.12.25-ны 12-1/8507 тоот албан бичиг, аймгийн Засаг даргын 2019.12.16-ны А/652 тоот захирамжаар нэмэлт санхүүжилтийн орлого зарцуулах зөвшөөрөл авсан хэдий ч хамт олны хурлаар хэлэлцэн батлаагүй байсан тул зөвлөмж өгөв.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.4-т “Энэ хуулийн 46.3.2, 46.3.3-т заасан урамшууллыг хуваарилах асуудлыг байгууллагын нийт ажилтныг оролцуулсан хамт олны хурлаар хэлэлцэн, шийдвэрлэх бөгөөд хамт олны хурлын тэмдэглэл болон шийдвэрийг үндэслэн тухайн шатны төрийн сан зарцуулах эрх олгоно” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Зөвлөмж өгөх

Аудитаар илэрсэн 1891,1 мянган төгрөгийн алдаа, зөрчилд төлбөрийн актыг төсөвт төвлөрүүлэн, 306,9 мянган төгрөгийн албан шаардлагын зөрчлийг арилгаж, 4869,3 мянган төгрөгийн зөвлөмж өгснийг 2020 оны 05 дугаар сарын 01-ны дотор хариу ирүүлэх.

2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Баянхонгор аймгийн нэгдсэн эмнэлгийн худалдан авах үйл ажиллагаа тендер зохион байгуулалт, эмийн зардлыг дараагийн аудитаар авч үзэх шаардлагатай гэж үзлээ.

2.13. Шилэн дансны мэдээлэл

Баянхонгор аймгийн Нэгдсэн эмнэлгийн Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 141 мэдээллийг хугацаанд нь, 9 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан, 1 мэдээллийг байршуулах хугацаа болоогүй байна.

д/д	Хугацаа	Төрөл	Удаа	Хугацаанд оруулсан	Хугацаа хоцроосон	Хугацаа болоогүй
1	Бүтэн жил	11	11	10		1
2	Хагас жил	4	4	4		
3	Улирал бүр	1	4	4		
4	Сар бүр	3	36	36		
5	Тухай бүр	8	96	87	9	
	Нийт	27	151	141	9	1

Хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээний тендерийн ерөнхий мэдээлэл /тухай бүр/ байршуулах мэдээллийг 1-9 сард хугацаа хоцроож мэдээлсэн байна.

2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх аудитаар акт тогтоогдсон төлбөрийн акт, зөвлөмжийг хугацаандаа биелүүлсэн байна.

2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Баянхонгор аймгийн Нэгдсэн эмнэлгийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Зөрчилгүй” дүгнэлт

Баянхонгор аймгийн Нэгдсэн эмнэлгийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4.1.3 дахь заалт, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Аудит хийгдсэн санхүүгийн тайлан

1.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	583,885,739.33	601,623,694.45
33	АВЛАГА	5,283,795.62	5,283,795.62
33300	Татаас, санхүүжилтийн авлага	967,829.62	967,829.62
335	Бусад авлага	4,315,966.00	4,315,966.00
3351	Байгууллагаас авах авлага	4,315,966.00	4,315,966.00
35	БАРАА МАТЕРИАЛ	578,601,943.71	596,339,898.83
351	Түүхий эд материал	275,847,574.14	249,537,853.66
35110	Тусгай зориулалттай материал	93,604,958.98	80,274,958.98
35130	Эм боох материал	182,242,615.16	169,262,894.68
354	Хангамжийн материал	302,754,369.57	346,802,045.17
35410	Бичиг хэргийн материал	710,000.00	1,167,000.00
35420	Аж ахуйн материал	8,294,106.52	6,124,106.52
35430	Сэлбэг хэрэгсэл	5,915,181.24	5,451,456.84
35450	Барилгын засварын материал	2,676,984.00	2,994,484.00
35460	Хүнсний материал	00.00	611,400.00
35470	Бусад хангамжийн материал	285,158,097.81	330,453,597.81
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	8,771,751,127.81	11,808,465,422.29
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	8,771,751,127.81	11,808,465,422.29
392	Биет хөрөнгө	7,323,683,129.88	10,360,640,422.29
39201	Барилга, байгууламж, орон сууц	5,112,638,500.00	8,428,638,500.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	00.00	-209,954,137.00
39203	Авто-тээврийн хэрэгсэл	348,281,277.00	371,716,277.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-219,392,770.42	-225,874,033.70
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	5,937,933,974.21	5,589,280,891.13
39206	Хуримтлагдсан элэгдэл	-	-
		3,964,330,787.98	-3,698,644,725.62
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	456,408,724.74	408,570,973.98
39208	Хуримтлагдсан элэгдэл	-347,855,787.67	-303,093,323.50
393	Биет бус хөрөнгө	1,448,067,997.93	1,447,825,000.00
39301	Програм хангамж	5,146,900.00	5,146,900.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-4,903,902.07	-5,146,900.00
39303	Бусад биет бус хөрөнгө	1,448,917,000.00	1,448,917,000.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	-1,092,000.00	-1,092,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	9,355,636,867.14	12,410,089,116.74
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	9,355,636,867.14	12,410,089,116.74
51	Засгийн газрын хувь оролцоо	9,355,636,867.14	12,410,089,116.74
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	6,725,816,344.70	6,725,816,344.70
51101	Өмч: - төрийн	6,725,816,344.70	6,725,816,344.70
512	Хуримтлагдсан үр дүн	-512,631,185.94	2,606,714,079.66
51210	Өмнөх үеийн үр дүн	-512,631,185.94	-447,738,169.94
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	3,054,452,249.60
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	3,142,451,708.38	3,077,558,692.38
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	9,355,636,867.14	12,410,089,116.74

4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	7,607,077,167.48	11,921,723,386.07
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	680,230,298.48	3,876,956,916.07
120	Нийтлэг татварын бус орлого	309,146,915.98	3,876,956,916.07
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	309,146,915.98	3,876,956,916.07
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	147,397,483.00	154,870,950.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	161,749,432.98	3,722,085,966.07
122	Тусламжийн орлого	371,083,382.50	00.00
122001	Хандив тусламж /дотоод/	101,966,685.50	00.00
122002	Хандив тусламж /гадаад/	269,116,697.00	00.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	6,926,846,869.00	8,044,766,470.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	3,211,882,300.00	3,941,128,600.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	3,211,882,300.00	3,941,128,600.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	345,491,917.00	152,681,740.00
131103	ЗГНХ,ЗДНХХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	31,500,000.00	00.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	82,971,417.00	00.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	231,020,500.00	152,681,740.00
1330	Төсвийн захирагчдаас	16,397,793.00	00.00
133003	Хөрөнгийн	16,397,793.00	00.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	3,353,074,859.00	3,950,956,130.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	89,909,662.00	00.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	3,263,165,197.00	3,950,956,130.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	7,875,610,693.21	8,861,664,412.46
21	УРСГАЛ ЗАРДАЛ	7,875,610,693.21	8,861,664,412.46
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	7,696,025,861.25	8,847,539,373.95
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	3,799,442,446.00	4,668,472,318.00
210101	Үндсэн цалин	3,799,442,446.00	4,668,472,318.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	457,795,304.00	596,327,921.00
210201	Тэтгэврийн даатгал	307,650,761.00	409,506,427.00
210202	Тэтгэмжийн даатгал	37,153,333.00	48,036,556.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	31,792,288.00	37,796,924.00
210204	Ажилгүйдлийн даатгал	7,381,721.00	9,180,729.00
210205	Эрүүл мэндийн даатгал	73,817,201.00	91,807,285.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	719,738,762.00	937,312,536.00
210301	Гэрэл, цахилгаан	68,343,408.00	88,963,201.00
210302	Түлш, халаалт	542,492,285.00	655,482,960.00
210303	Цэвэр, бохир ус	108,903,069.00	192,866,375.00
2104	Хангамж, бараа материалын зардал	157,248,305.94	169,804,953.00
210401	Бичиг хэрэг	27,151,006.00	21,808,162.00
210402	Тээвэр, шатахуун	68,184,755.00	75,878,777.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	10,065,857.00	10,857,114.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	51,521,687.94	55,146,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	325,000.00	6,114,400.00

2105	Нормативт зардал	1,513,241,427.96	1,622,018,682.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,293,487,254.15	1,405,412,382.00
210502	Хоол, хүнс	183,822,173.81	200,026,300.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	35,932,000.00	16,580,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	80,337,867.01	79,779,224.40
210601	Багаж, техник, хэрэгсэл	730,000.00	00.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	4,276,400.00	00.00
210604	Урсгал засвар	75,331,467.01	79,779,224.40
2107	Томилолт, зочны зардал	20,498,660.00	17,969,000.00
210702	Дотоод албан томилолт	20,498,660.00	17,969,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	47,275,868.00	41,190,891.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	42,853,860.00	31,574,691.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,980,000.00	1,980,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	623,700.00	712,800.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	1,398,100.00	712,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	255,178.00	242,000.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	165,030.00	5,969,400.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	900,447,220.34	714,663,848.55
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	900,447,220.34	714,663,848.55
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	179,584,831.96	14,125,038.51
2132	Бусад урсгал шилжүүлэг	179,313,516.00	13,798,210.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	89,909,662.00	00.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	00.00	1,263,868.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	82,362,354.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	7,041,500.00	12,534,342.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	271,315.96	326,828.51
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	271,315.96	326,828.51
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-268,533,525.73	3,060,058,973.61
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	53,405.65	5,606,724.01
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	50,906.25	5,606,724.01
225007	Хөрөнгийн дахин үнэлгээний зардал	2,499.40	00.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-53,405.65	-5,606,724.01
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-268,586,931.38	3,054,452,249.60

4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	7,062,643,163.00	8,199,637,420.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	152,194,087.00	154,870,950.00
120	Нийтлэг татварын бус орлого	152,194,087.00	154,870,950.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	152,194,087.00	154,870,950.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	147,397,483.00	154,870,950.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	4,796,604.00	00.00

13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	6,910,449,076.00	8,044,766,470.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	3,211,882,300.00	3,941,128,600.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	3,211,882,300.00	3,941,128,600.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	345,491,917.00	152,681,740.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилалдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	31,500,000.00	00.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	82,971,417.00	00.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	231,020,500.00	152,681,740.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	3,353,074,859.00	3,950,956,130.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	89,909,662.00	00.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	3,263,165,197.00	3,950,956,130.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	7,029,538,263.00	8,117,049,420.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	7,029,538,263.00	8,117,049,420.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	6,849,953,431.04	8,110,882,591.49
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	3,817,031,695.00	4,608,629,300.00
210101	Үндсэн цалин	2,082,846,595.00	2,679,365,200.00
210102	Нэмэгдэл	1,371,182,900.00	1,445,111,600.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	177,144,000.00	216,216,000.00
210104	Урамшуулал	185,858,200.00	267,936,500.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	440,445,175.00	572,328,700.00
210201	Тэтгэврийн даатгал	293,671,775.00	390,071,500.00
210202	Тэтгэмжийн даатгал	36,693,300.00	45,564,300.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	29,354,700.00	36,451,400.00
210204	Ажилгүйдлийн даатгал	7,338,700.00	9,112,900.00
210205	Эрүүл мэндийн даатгал	73,386,700.00	91,128,600.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	719,738,762.00	937,312,536.00
210301	Гэрэл, цахилгаан	68,343,408.00	88,963,201.00
210302	Түлш, халаалт	542,492,285.00	655,482,960.00
210303	Цэвэр, бохир ус	108,903,069.00	192,866,375.00
2104	Хангамж, бараа материалын зардал	156,320,203.00	164,859,926.00
210401	Бичиг хэрэг	9,287,736.00	10,318,562.00
210402	Тээвэр, шатахуун	66,388,690.00	74,188,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	10,065,857.00	10,857,114.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	40,558,800.00	42,334,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	30,019,120.00	27,162,250.00
2105	Нормативт зардал	1,551,693,378.04	1,599,560,439.49
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,348,867,848.04	1,368,487,239.49
210502	Хоол, хүнс	179,821,530.00	200,637,700.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	23,004,000.00	30,435,500.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	74,787,450.00	46,400,150.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	7,340,000.00	140,900.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	11,454,300.00	7,710,000.00
210604	Урсгал засвар	55,993,150.00	38,549,250.00
2107	Томилолт, зочны зардал	20,498,660.00	15,322,000.00
210702	Дотоод албан томилолт	20,498,660.00	15,322,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	69,438,108.00	166,469,540.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	48,827,230.00	145,316,740.00

Баянхонгор аймгийн Нэгдсэн эмнэлгийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,980,000.00	1,980,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	623,700.00	712,800.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	1,398,100.00	712,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	255,178.00	242,000.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	16,353,900.00	17,506,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	179,584,831.96	6,166,828.51
2132	Бусад урсгал шилжүүлэг	179,313,516.00	5,840,000.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	89,909,662.00	00.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	82,362,354.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	7,041,500.00	5,840,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	271,315.96	326,828.51
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	271,315.96	326,828.51
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	33,104,900.00	82,588,000.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	33,104,900.00	82,588,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	33,104,900.00	82,588,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	33,104,900.00	82,588,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	33,104,900.00	82,588,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-33,104,900.00	-82,588,000.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	5,277,991,344.70	2,935,236,347.00	-119,985,806.28	8,093,241,885.42
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	5,277,991,344.70	2,935,236,347.00	-119,985,806.28	8,093,241,885.42
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-110,448,584.16	-110,448,584.16
C08	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	6,725,816,344.70	3,142,451,708.38	-512,631,185.94	9,355,636,867.14
D01	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	6,725,816,344.70	3,142,451,708.38	-512,631,185.94	9,355,636,867.14

D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	64,893,016.00	64,893,016.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	6,725,816,344.70	3,142,451,708.38	-447,738,169.94	9,420,529,883.14
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	-64,893,016.00	00.00	-64,893,016.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	3,054,452,249.60	3,054,452,249.60
D09	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	6,725,816,344.70	3,077,558,692.38	2,606,714,079.66	12,410,089,116.74

4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Дүн	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	8,047,112,100.00	8,046,628,851.49	483,248.510	99.99
21	УРСГАЛ ЗАРДАЛ	8,047,112,100.00	8,046,628,851.49	483,248.510	99.99
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	8,041,272,100.00	8,040,788,851.49	483,248.510	99.99
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	4,608,629,300.00	4,608,629,300.00	0.000	100.00
210101	Үндсэн цалин	2,679,365,200.00	2,679,365,200.00	0.000	100.00
210102	Нэмэгдэл	1,445,111,600.00	1,445,111,600.00	0.000	100.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	216,216,000.00	216,216,000.00	0.000	100.00
210104	Урамшуулал	267,936,500.00	267,936,500.00	0.000	100.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	572,328,700.00	572,328,700.00	0.000	100.00
210201	Тэтгэврийн даатгал	390,071,500.00	390,071,500.00	0.000	100.00
210202	Тэтгэмжийн даатгал	45,564,300.00	45,564,300.00	0.000	100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	36,451,500.00	36,451,400.00	100.000	100.00
210204	Ажилгүйдлийн даатгал	9,112,900.00	9,112,900.00	0.000	100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	91,128,500.00	91,128,600.00	-100.000	100.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	937,337,400.00	937,312,536.00	24,864.000	100.00
210301	Гэрэл, цахилгаан	90,211,000.00	88,963,201.00	1,247,799.000	98.62
210302	Түлш, халаалт	655,812,900.00	655,482,960.00	329,940.000	99.95
210303	Цэвэр, бохир ус	191,313,500.00	192,866,375.00	1,552,875.000	100.81
2104	Хангамж, бараа материалын зардал	174,971,700.00	174,943,926.00	27,774.000	99.98
210401	Бичиг хэрэг	8,247,500.00	10,318,562.00	2,071,062.000	125.11

210402	Тээвэр, шатахуун	76,085,900.00	74,188,000.00	1,897,900.000	97.51
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	12,146,000.00	10,857,114.00	1,288,886.000	89.39
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	42,681,300.00	42,334,000.00	347,300.000	99.19
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	35,811,000.00	37,246,250.00	1,435,250.000	104.01
2105	Нормативт зардал	1,604,229,100.00	1,603,960,439.49	268,660.510	99.98
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,372,750,000.00	1,372,887,239.49	-137,239.490	100.01
210502	Хоол, хүнс	202,659,100.00	200,637,700.00	2,021,400.000	99.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	28,820,000.00	30,435,500.00	1,615,500.000	105.61
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	92,140,800.00	92,139,150.00	1,650.000	100.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	30,000,000.00	32,414,900.00	2,414,900.000	108.05
210602	Тавилга	10,000,000.00	8,634,000.00	1,366,000.000	86.34
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	13,004,300.00	11,690,000.00	1,314,300.000	89.89
210604	Урсгал засвар	39,136,500.00	39,400,250.00	-263,750.000	100.67
2107	Томилолт, зочны зардал	15,481,500.00	15,322,000.00	159,500.000	98.97
210702	Дотоод албан томилолт	15,481,500.00	15,322,000.00	159,500.000	98.97
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	36,153,600.00	36,152,800.00	800.000	100.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	15,000,000.00	15,000,000.00	0.000	100.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,980,000.00	1,980,000.00	0.000	100.00
210803	Даатгалын үйлчилгээ	712,800.00	712,800.00	0.000	100.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	712,800.00	712,000.00	800.000	99.89
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	242,000.00	242,000.00	0.000	100.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	17,506,000.00	17,506,000.00	0.000	100.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	5840000.00	5840000.00	0.000	100.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	5,840,000.00	5,840,000.00	0.000	100.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	5,840,000.00	5,840,000.00	0.000	100.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	8,047,112,100.00	8,046,628,851.49	483,248.510	99.99
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	3,941,128,600.00	3,940,801,771.49	326,828.510	99.99
131001	Улсын төсвөөс санхүүжих	3,941,128,600.00	3,940,801,771.49	326,828.510	99.99
1340	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	3,951,112,500.00	3,950,956,130.00	156,370.000	100.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	3,951,112,500.00	3,950,956,130.00	156,370.000	100.00
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	154,871,000.00	154,870,950.00	50.000	100.00

1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	154,871,000.00	154,870,950.00	50.000	100.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	312	366	-54	117
620001	Удирдах ажилтан	01	02	-01	200
620002	Гүйцэтгэх ажилтан	140	264	-124	189
620003	Үйлчлэх ажилтан	171	100	71	58
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	312	366	-54	117
650008	Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ)	272	323	-51	119
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	40	43	-03	108

4.6 Аудит хийгдсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	0.00	152,681,740,00
2132	Бусад урсгал шилжүүлэг		152,681,740,00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг		152,681,740,00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		152,681,740,00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	0.00	152,681,740,00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		152,681,740,00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		152,681,740,00

АУДИТЫН ТАЙЛАНГ

БЭЛТГЭСЭН:

АУДИТОР:

П. Амаржаргал

П.АМАРЖАРГАЛ

АНХАН ШАТАНД ХЯНАСАН:

АУДИТЫН МЕНЕЖЕР:

А.Цээням

А.ЦЭЭНЯМ

ХОЁР ДАХЬ ШАТАНД ХЯНАСАН:

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:

Б.Мөнхбат

Б.МӨНХБАТ